



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/Н/12

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 8 дугаар хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймагт шинэ үеийн барилгын салбар байгуулагдаж хөгжсөний 60 жилийн ой, барилгачдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдах аймгийн Засаг даргын нэрэмжит “Өрөг угсрагч мэргэжлийн ажилчдын ур чадварын” аймгийн аварга шалгаруулах тэмцээн, барилгын салбарт нэвтэрсэн шинэ технологи танилцуулах сургалт зохион байгуулахад 5 000 000 /таван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатарт/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201010490

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дугаар
сарын 16-ны өдрийн 442 дугаар
захирамжийн хавсралт.

№8	Зардлын зүйл	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Тоо ширхэг	Нийт дүн /төгрөг/
1	Тэмцээний шагнал			
	1-р байр	500000	1	500000
	2-р байр	400000	1	400000
	3-р байр	300000	1	300000
	Тусгай байр	200000	1	200000
2	Сургалтанд оролцогсдын өдөр, оройн хоол	35000	100	3500000
	Бүгд			5 000 000